



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ОРА-2026/007/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: purevkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Цэцэгмаа

Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,  
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033  
Утас: (976) 7035 9826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.15 № 91  
танай -ны № -т

ЭРДЭНЭТ УС ДУЛААН ТҮГЭЭХ  
СҮЛЖЭЭ ОНӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Г. ЭРДЭНЭБАТ  
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

“Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах 2025 оны худалдан авах бараа материал, ажил үйлчилгээний төлөвлөгөөг 2,927,556.6 мянган төгрөгөөр баталсныг төлөөлөн удирдах зөвлөлийн тодотголоор 55,547.6 мянган төгрөгөөр өсгөжээ.

**Аудитын гол асуудал**

“Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан байна.

Тайлант онд 1,559,999.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь төлөвлөснөөс 832,333.8 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

## Бусад асуудлын хэсэг

“Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилт, 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг төлөөлөн удирдах зөвлөлийн 01 дугаар тогтоолоор 99.1 хувьтай дүгнэгдсэн байна.

### Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

## ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,628,605,586.12	6,182,543,715.56
2	Дансны авлага	17,383,560,730.13	19,846,826,354.64
3	Татвар, НДШ-ийн авлага	9,590,027.96	22,648,310.91
4	Бусад авлага	2,198,888.62	5,429,709.31
5	Бусад санхүүгийн хөрөнгө	3,905,772,615.65	4,164,918,898.22
6	Бараа материал	1,159,680,055.07	4,021,819,944.83
7	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,089,407,903.55	34,244,186,933.47
8	Үндсэн хөрөнгө	61,955,434,295.02	79,992,362,278.12
9	Биет бус хөрөнгө	206,328,872.41	161,625,832.33
10	Бусад эргэлтийн бус хөрөнгө	8,221,728,863.87	12,941,882,311.87
11	Газар / Биет бус хөрөнгө - Бусад /	2,480,362,800.00	2,475,865,800.00
12	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	72,863,854,831.30	95,571,736,222.32
13	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	99,953,262,734.85	129,815,923,155.79
14	Дансны өглөг	16,279,597,387.33	20,329,033,866.95
15	Татварын өр	29,645,481.40	14,373,529.58
16	Урьдчилж орсон орлого	1,233,799,569.45	872,400,477.34
17	Бусад богино хугацаат өр төлбөр	38,779,769.45	27,128,438.66
18	Богино хугацаат өр төлбөрийн дүн	17,581,822,207.63	21,242,936,312.53
19	Хойшлогдсон орлого	8,221,728,863.87	12,941,882,311.87
20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	8,221,728,863.87	12,941,882,311.87
21	Өр төлбөрийн нийт дүн	25,803,551,071.50	34,184,818,624.40
22	Өмч: - төрийн	5,231,568,753.18	5,231,568,753.18
23	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,533,757,257.78	2,533,503,314.46
24	Эздийн өмчийн бусад хэсэг	72,104,219,705.37	95,977,946,363.11
25	Хуримтлагдсан ашиг	-5,719,834,052.98	-8,111,913,899.36
26	Тайлангийн үеийн ашиг	0.00	-2,392,333,789.70
27	Өмнөх үеийн ашиг	-5,719,834,052.98	-5,719,580,109.66
28	Эздийн өмчийн дүн	74,149,711,663.35	95,631,104,531.39
29	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	99,953,262,734.85	129,815,923,155.79

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	31,648,614,668.87	35,890,548,307.52
2	Борлуулалтын өртөг	17,966,809,993.80	21,312,327,035.14
3	Нийт ашиг( алдагдал)	13,681,804,675.07	14,578,221,272.38
8	Бусад орлого	253,773,253.82	316,973,672.26
9	Орлогын дүн	253,773,253.82	316,973,672.26
10	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
11	Ерөнхий ба удирдлагын зардал	14,770,725,112.34	18,503,693,188.20
12	Санхүүгийн зардал	0.00	0.00

13	Бусад зардал	0.00	0.00
14	Зардлын дүн	14,770,725,112.34	18,503,693,188.20
15	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
16	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
17	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
18	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
19	Бусад ашиг ( алдагдал)	777,337,655.56	1,227,482,552.60
20	Олз, гарзын дүн	777,337,655.56	1,227,482,552.60
21	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	-57,809,527.89	-2,381,015,690.96
22	Орлогын татварын зардал	10,485,334.58	11,318,098.74
23	Татварын дараах ашиг (алдагдал)	-68,294,862.47	-2,392,333,789.70
24	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
25	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-68,294,862.47	-2,392,333,789.70

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,231,568,753.18	-5,671,209,806.51	66,932,098,959.82
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	19,670,616.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	-68,294,862.47	-68,294,862.47
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	7,285,907,566.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,231,568,753.18	-5,719,834,052.98	74,149,711,663.35
11	Залруулсан үлдэгдэл	0.00	253,943.32	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	-2,392,333,789.70	-2,392,333,789.70
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	23,873,726,657.74
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	5,231,568,753.18	-8,111,913,899.36	95,631,104,531.39

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
2	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3	Мөнгөн орлогын дүн (+)	35,427,439,100.14	42,113,094,620.18
4	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	32,241,122,033.37	37,696,669,009.41
8	Татаас, санхүүжилтийн орлого	250,000,000.00	300,000,000.00
9	Бусад мөнгөн орлого	2,936,317,066.77	4,116,425,610.77
10	Мөнгөн зарлагын дүн (-)	34,088,455,336.68	40,080,600,070.74
11	Ажиллагчдад төлсөн	6,083,567,621.18	8,058,652,021.86
12	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,923,518,139.00	2,476,800,000.00
13	Бараа материал худалдан авахад төлсөн	2,047,536,051.20	1,450,907,445.00
14	Ашиглалтын зардалд төлсөн	412,109,233.00	1,021,535,181.37
15	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	249,643,500.00	252,062,960.00
16	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
17	Татварын байгууллагад төлсөн	1,702,126,138.25	2,339,067,127.52
18	Даатгалын төлбөрт төлсөн	1,841,670.00	0.00
19	Бусад мөнгөн зарлага	21,668,112,984.05	24,481,575,334.99
20	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,338,983,763.46	2,032,494,549.44
31	Мөнгөн зарлагын дүн (-)	811,762,160.00	478,556,420.00
32	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	744,659,285.00	478,556,420.00
33	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	67,102,875.00	0.00
38	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-811,762,160.00	-478,556,420.00
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	527,221,603.46	1,553,938,129.44
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,101,383,982.66	4,628,605,586.12

54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,628,605,586.12	6,182,543,715.56
----	---	------------------	------------------

## 2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он			
				Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (хувиар)
<b>1. Ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн буюу техникийн үзүүлэлт</b>							
1	Цахилгаан эрчим	Айл өрх					
	хүчээр хангах хэрэглэгчид		11193	11193	13397	2204	119,7
1.1		ААНБ	1315	1315	1351	36	102.7
1.2	Дулаанаар хангах хэрэглэгчид	Айл өрх	14947	17131	17131	0	
		ААНБ	1325	1476	1475	-1	
1.3	Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ	Айл өрх	16070	16070	16182	112	100.7
		ААНБ	2180	2180	2194	14	100.6
1.4	Ус түгээх байр	ширхэг	94	99	106	7	107.07
1.5	Ажиллагсад	хүн	314	324	317	-7	
1.6	Дундаж цалин	Мян.төг	28,001,139.9	25,905,64.8	2,554,694.0	-35,870.8	
<b>2. Орлого, зардал, ашгийн буюу эдийн засгийн үзүүлэлт</b>							
2.1	<b>Нийт орлого</b>	<b>Мян.төг</b>	<b>32,691,021.8</b>	<b>36,722,862.2</b>	<b>37,443,930.5</b>		<b>101.96%</b>
2.1.1	Цахилгаан	Мян.төг	10,017,306.5	14,278,132.6	14,379,276.9	101,144.3	101%
2.1.2	Дулаан	Мян.төг	12,533,300.2	12,635,330.7	13,270,803.5	635,472.86	105%
2.1.3	Цэвэр ус хангамж	Мян.төг	5134,334.0	5,100,659.8	4,910,647.2	190,092.6	96%
2.1.4	Ариутгах татуурга	Мян.төг	3,612,508.4	3,560,000	3,600,158.5	40,158.5	101%
2.1.5	Цахилгаан шат	Мян.төг	188,700.8	180,000	175,579.5		
2.1.6	ӨЭҮҮ хангамж	Мян.төг	904,741.5	876,289.1	968,178.7	91,889.6	110%
2.1.7	Тоолуурын хэсэг	Мян.төг	99,845.6	90,000	110,715	207,14.8	122%
2.1.8	Бусад	Мян.төг	173,401.7	26,121.3	26,121.3	0	0
2.2	<b>Нийт зардал</b>	<b>мян.төг</b>	<b>32,759,316.7</b>	<b>39,692,162.2</b>	<b>39,836,264.3</b>	<b>144,102.13</b>	<b>100.36%</b>
2.2.1	Үндсэн цалин	Мян.төг	7,444,240.5	10,072,116.2	9,718,056	354,060.18	96.48%
2.2.2	НДШ	Мян.төг	1,025,384.8	1,367,716.7	1,320,896.8	-46,819.81	96.58%
2.2.3	Цахилгаан	Мян.төг	1,120,134.2	1,638,557.9	1,648,817.3	10,259.48	100.63%
2.2.4	Дулаан	Мян.төг	23,706.9	30,761.00	23,192.8	-7,568.16	75.4%
2.2.5	Ус	Мян.төг	15,197.8	63,709.4	38,226.00	-25,483.42	60.0%

2.2.6	Урсгал завсар, сэлбэг	Мян.төг	514,066.6	505,121.3	452,791.8	-52,329.5	89.6%
2.2.7	Түлш шатахуун	Мян.төг	166,997.3	331,916.3	161,762.2	170,154.13	48.74%
2.2.8	Албан томилолт	Мян.төг	24,283.2	20,352.2	20,198	-154.17	99.24%
2.2.9	Бичиг хэрэг	Мян.төг	30,125.6	51,126.6	26,951.7	-24,174.91	52.72%
2.2.10	Холбоо	Мян.төг	32,054.7	38,357.6	29,851.1	-8,506.47	77.82%
2.2.11	Хөдөлмөр хамгаалал	Мян.төг	276,608.7	475,090.2	382,473.3	-926,16.8	80.51%
2.2.12	Элэгдэл	Мян.төг	3,,235,285.9	3,670,926.7	3,942,254.9	271,328.16	107.39%
2.2.13	Зар сурталчилгаа	Мян.төг		4,333	416.3	-3,916.72	9.61%
2.2.14	Нийгмийн халамж	Мян.төг	367,409.0	511,836.3	4,041,76.4	107,659.91	78.97%
2.2.15	ТЗЭ-ийн зохицуулалтийн хөлс	Мян.төг	60,485.7	70,116.2	68,666.2	-1,450.04	97.93%
2.2.16	Татвар, даатгалын зардал	Мян.төг	28,704.5	45,158.9	29,069.6	-16,089.3	67.34%
2.2.17	Гаднын үйлчилгээний хөлс	Мян.төг	79,912.8	114,545.9	75,002.2	-39,543.66	65.48%
2.2.18	Бусад үндсэн үйл ажиллагаа	Мян.төг	326,126.8	193,220	160,890.6	-32,329.39	83.27%
2.2.19	Худалдан авсан эрчим хүч	Мян.төг	17,966,810.0	20,438,200.1	21,312,327	8741,26.98	104.28%
2.2.20	Үйл ажиллагааны бус зардал	Мян.төг	21,781.5	49,000	2,044.1	-28,755.9	41.31%
2.3	Ашиг, алдагдал	Мян.төг	-68,294.8	-2,969,300.0	-2,392,333.8	576,966.15	80.57%

## **ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 65,923.3 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 37,757.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааг сайжруулах 4 зөвлөмж өгсөн.

### **3.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### **3.2 Албан шаардлага**

Үйлдвэрлэлийн осолд орж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжтэй байх хугацаанд 2,293.6 мянган төгрөгийн цалин олгосон, гүйцэтгэх захирлын тушаал шийдвэргүй үр дүнгийн шагналт цалинд 35,281.7 мянган төгрөг олгосон, баталгаажуулаагүй зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

Компанийн бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 16,776.0 мянган төгрөгөөр тоосго худалдан авч, гүйцэтгэх захирлын тушаалыг үндэслэн зарцуулсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", 84.6-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө" гэж заасныг зөрчсөн байна.

##### **Өгсөн зөвлөмж:**

Компанийн бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгийг худалдан авахгүй байх.

#### **2. Урсгал зардлын данстай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

Сар шинийн баярыг тохиолдуулан компанийн золголтын үйл ажиллагаанд 672.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", 84.6-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:", 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад." 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Хууль, тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр ажилчдад дэмжлэг олгохгүй байх.

**3. Урсгал зардлын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Компанийн 2025 оны шилдэг алба, ажилтнуудын шагналд 9,635.0 мянган төгрөгийн төсөв баталж зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.9-д "хариуцлагатай байх", 4.2-д "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 4.2.3-д "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.3-д "Төрийн хэмнэлтийн хуулийг чанд мөрдөж, төсвийн хөрөнгөөр шинэ жил, байгууллагын болон салбарын ой тэмдэглэх зэрэг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахгүй, бэлэг дурсгалын зүйл бэлтгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Компанийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл авч, шинэ жил арга хэмжээ зохион байгуулахгүй байх.

**4. Урсгал зардлын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Тайлант онд удирдах 1 албан хаагчид шууд харьяалан удирдуулах албан тушаалтны ажлыг хавсруулж, 1,264.5 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагааг явуулахыг хориглоно", 12.1-т "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Ажил хавсруулах тушаал гаргахдаа шууд харьяалан удирдуулах албан тушаалтны ажлыг хавсруулахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**ДӨРӨВ. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Албан хаагч нь В. Баяртогтох нь 2025 оны 5 сард үйлдвэрлэлийн осолд орж хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжтэй байх хугацаанд 2,293.6 мянган төгрөгийн цалин олгосон	1	2,293.6			1	2,293.6							
Тайлант оны эцэст албан хаагчдад сарын үр дүнгийн шагналт цалин 35,281.7 мянган төгрөгийг гүйцэтгэх захирлын тушаал шийдвэргүй, хамт олны хурлын тэмдэглэл байхгүй олгосон	1	35,281.7			1	35,281.7							

Сар шинийн баярыг тохиолдуулан компанийн золголтын үйл ажиллагаанд 672.5 мянган төгрөгийг зарцуулсан байна	1	672.5					1	672.5				
Компанийн 2025 оны шилдэг алба, ажилтнуудын шагналд 9,635.0 мянган төгрөгийн төсөв баталж зарцуулсан байна.	1	9,635.0					1	9,635.0				
Тайлант онд удирдах 1 албан хаагчид шууд харьяалан удирдуулах албан тушаалтны ажлыг хавсруулж 1,264.5 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.	1	1,264.5					1	1,264.5				
<b>ДҮН:</b>	<b>6</b>	<b>65,923.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>37,575.3</b>	<b>4</b>	<b>28,348.0</b>				

